





An aerial photograph of a mining site. In the foreground, there is a large area filled with numerous small, colorful tents or temporary structures, likely a workers' camp. The ground is brown and dusty. In the background, a massive, towering plume of reddish-brown dust or sand rises into the sky, partially obscuring the view of the mountains behind it. The sky is overcast with grey clouds.

**УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД  
ЗОХИЦСОН НИЙГМИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭ**

# УАӨ: Зүүн Өмнөд Ази, Номхон далайн бүс



## Зүүн Ази, Номхон далайн бүс нутагт:

- үер **11** дахин,
- шуурга **4** дахин,
- ган гачиг **2.4** дахин,
- хөрсний нуралт **5** дахин нэмэгдсэн байна.

## НҮБ-ын Хүүхдийн Сангийн тооцоолсноор:

- **140 сая** хүүхэд усны гачигдалд;
- **120 сая** хүүхэд далайн эрэг хавийн усны үерт;
- **210 сая** хүүхэд хар салхи циклонд;
- **460 сая** хүүхэд агаарын бохирдолд өртөж байна.



**Филиппин улсад 2020 онд түүхэн дэх хамгийн хүчтэй халуун орны циклонуудын нэг болох гони хар салхи болж, 69 сая хүн, 700,000 гаруй хүүхэд өртсөн. Шуурга их хэмжээний сүйрэлд хүргэж, аадар бороо, үер, хөрсний гулгалт болон хүчтэй салхи орон сууц, дэд бүтэц, газар тариалангийн талбайг сүйтгэсэн. Хар салхины улмаас эрүүл мэнд, цэвэр ус, боловсрол зэрэг нийгмийн үйлчилгээ тасалдсан. Олон сургуулиуд нурж эвдэрсэн, сүйрсэн, олон мянган хүүхэд гэр орноо орхин дүрвэсэн.**

**2022 онд хөрсний гулгалтын улмаас Малайзын Батанг Кали хотод 33 хүн (түүний дотор 5 хүүхэд) нас барсан.**





# Монгол Улсын хувьд:

- 1 сая гаруй хүүхэд усны гачигдалд
- 90,000 орчим хүүхэд голын үер усанд
- 1,1 сая хүүхэд хэт халуун/дулааны долгионд
- 260,000 хүүхэд агаарын бохирдолд
- Хүүхдүүдийн 90.1 хувь нь 2 ба түүнээс дээш гамшигт, 25.2 хувь нь 3 ба түүнээс дээш гамшигт өртөх эрсдэлтэй.

Монголын энгийн хуй салхи дулаан орны эрчит хуйлраа болж сүйрэл дагуулах магадлал хир вэ?

2014.7 29. Архангай аймгийн Хашаат суманд болсон байгалийн гоц үзэгдлийн улмаас нэг хүн нас барж, есөн хүн гэмтэж бэртэн 10 үхэр, 100 хонь, 88 адуу үрэгдсэн байна









Үер нь Монгол улсын ДНБ-д **37 сая** ам долларын сөрөг нөлөө үзүүлж, жилд **10100 хүн** өртөх магадлалтай гэсэн тооцоог гаргажээ (Mongolia's Third National Communication under UNFCCC, 2018). 2004–2015 оны хооронд буюу 10 жилийн хугацаад **599** удаа үерийн гамшиг тохиолдсон. 2023 оны 7-8 сард болсон үерт **31,600** өрхийн **128,000** хүн хохирол амсаж өртсөн.






2023 оны 11 сараас 2024 оны 3 сард манай улсын газар нутгийн 90 хувьд **зүд** нүүрлэж, **188,300 хүн**, үүнээс **80,215** хүүхэд (40,830 охид and 39,385 хөвгүүд) өртөж, боловсрол, эрүүл мэнд, ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ авах боломж нь хязгаарлагдсан.











# Тэгш бус байдал

Эдийн засаг	<ul style="list-style-type: none"><li>Амьжиргаа, эд хөрөнгөө алдсанаас болж орлогын ялгаа ихэснэ.</li><li>Хөрөнгө, санхүүгээ босгох боломж хязгаарлагдмал</li><li>Гамшигт өртсөн айл эдийн засгийн хүндрэлтэй тулгарсаны улмаас хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлнэ.</li><li>Сургуулийн барилга, дэд бүтэц нурж, бага насны хүүхдийн хөгжлийн үйлчилгээ, боловсролын хүртээмж буурна.</li><li>Хөрөнгөө барж өрхийн амьжиргаа доройтно.</li></ul>
Улс төр	<ul style="list-style-type: none"><li>Засгийн газарт итгэх итгэл суларна (Гамшигт өртсөн хүмүүс, нийтийн хэрэгцээг хангах чадамжгүй засаг төр гэж үзэх), улс төрийн тогтолцоо тогтворгүй болно.</li><li>Уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээнд зарцуулж байгаа нөөц, санхүүжилтыг тэгш бусаар хуваарилах</li><li>Хүүхэд, залуучууд өөрсдийнхөө сайн сайхан байдалд нөлөөлж байгаа асуудалд оролцож, саналаа илэрхийлэх, нөлөөлөх боломж хязгаарлагдмал.</li></ul>
Жендер	<ul style="list-style-type: none"><li>Онцгой байдлын үед эмэгтэйчүүд гэр бүлээ хоол хүнс, усаар хангах ачааллыг үүрдэг.</li><li>Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хүнсний аюулгүй байдлын асуудалд эмэгтэйчүүд харьцангуй өртөмтгий байдаг.</li><li>Газар тариалангийн ургац буурч, ургац алдах, эсвэл аюулт үзэгдэл тохиолдсоны дараа хүнсний хомсдолд орсон тохиолдолд өрхийн хүнсний хэрэглээ хамгийн түрүүнд буурдаг.</li><li>Гамшиг, нүүлгэн шилжүүлэлтийн үед жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх эрсдэл нэмэгддэг.</li><li>Эрт гэрлэх, бэлгийн мөлжлөгт өртөх, хүн худалдаалах эрсдэл</li><li>Боловсролын тэгш хүртээмжтэй байдал алдагдах</li></ul>
Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах	<ul style="list-style-type: none"><li>Нөөцийн хуваарилалт, гамшгийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэх явцад арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл нөлөөлөх</li><li>Шийдвэр гаргах үед арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл нөлөөлөх.</li></ul>
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	<ul style="list-style-type: none"><li>Гамшгийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмждэггүй/ хариу арга хэмжээ авдаггүй/ тооцохгүй байх.</li><li>Эрүүл мэнд, нөхөн сэргээх болон бусад тусламж үйлчилгээ тасалдаж, сөрөг үр дагаврыг илүүтэй мэдэрнэ.</li></ul>
Уугуул иргэд, малчин, тариаланчид, жижиг фермерийн амьдрал	<ul style="list-style-type: none"><li>Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр амьдарч дассан нутаг орноо орхиж явах, газраа алдах.</li><li>Уугуул иргэдийн амьдрал, амьжиргаа нь байгальтайгаа зохицсон байдаг тул уламжлалт амьжиргаа, хүнсний эх үүсвэрт аюул учирна.</li><li>Соёл устаж үгүй болох, мөн байгалийн унаган төрх алдагдах.</li><li>Лаван тунлах, нөхөн сэргээх нөөц багатай тул илүү их хохирол амсах</li></ul>

# Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон

Нийгмийн үйлчилгээ  
 Нийгмийн, хүүхэд хамгаалал  
 Мэдээллийн хүртээмж  
 Төлөвлөлт, бэлэн байдал  
 Амьжиргаа  
 Бодлого, засаглал





# Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон эрүүл мэндийн үйлчилгээ

- Эмнэлгүүдийг сэргээгдэх эрчим хүчээр хангах, барилга байгууламж, дэд бүтэц нь уур амьсгалд тэсвэртэй байх, ажилтнууд нь үйлчилгээгээ үзүүлэхийн тулд дасан зохицох **стратеги, төлөвлөгөөтэй** байх
- Орон нутагт иргэд, олон нийтийн оролцоотойгоор **эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх** тогтолцоог бэхжүүлэх.
- Эрүүл мэндэд нөлөөлж байгаа **хүрээлэн буй орчны бохирдол**, бусад хүчин зүйлсийг тодорхойлох, үүнээс үүдэлтэй **өвчлөлөөс** урьдчилан сэргийлэх, эмчлэх стратегид тусгах, уур амьсгалд мэдрэмтгий өвчлөлийг **тандалтын системд** тусгах, салбарын **бодлого, төлөвлөгөөнд** тусгах.
- Эрүүл мэндийн салбарт хүлэмжийн хийн ялгаралтай багатай эрчим хүч, орчны бохирдлыг бууруулах **технологи**, эрүүл мэндийн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж эрүүл мэндийн байгууллагуудын **экологийн үл мөрийг бууруулах**.

# Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон боловсролын үйлчилгээ

- Байгаль орчны тогтвортой байдал, УАӨ-д дасан зохицох, хүүхдийн эрхийг хангах асуудлыг **салбарын бодлогод** тусгах.
- УАӨ-ийг боловсролын салбарын **төлөвлөлт, санхүү, төсөвтэй** уялдуулах, хөрөнгө оруулах.
- Боловсролын бүх шатанд **сургалтын хөтөлбөрт** тусгах.
- УАӨ-д тэсвэртэй **барилга, эрчим хүч, дэд бүтцийг байгуулах**, хүлэмжийн хийн ялгарал, экологийн үл мөрийг бууруулах.
- УАӨ-ийг сааруулах, дасан зохицох стратеги, төлөвлөлтийг боловсруулахад **өсвөр үеийнхэн, залуучуудыг оролцуулах.**



СХД-ийн 74-р сургууль. 2024. НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэй байгуулсан нарны систем



# Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламж, үйлчилгээ

- УАӨ-ийн **бодлого, төлөвлөгөөнд** тусгах.
- Тойрог эдийн засгийн зарчмаар ус хангамж, ариун цэвийн байгууламжийг байгуулах **технологи, инноваци** /жишээ нь усыг дахин ашиглах /
- Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийн **хүртээмж** /ундны усыг 24/7 цаг авч хэрэглэх, ариун цэврийн байгууламж хөлдөхгүй байх/.
- **Сэргээгдэх, бие даасан эрчим хүчний эх үүсвэр ашиглах**, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах.





# НИЙТИЙН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ



Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламж, үйлчилгээ






# Хоол тэжээл

- **Хүнсний хангамж**, үнийг боломжийн түвшинд байлгах
- УАӨ-ийн эрсдэлтэй бүс нутаг, газрын хоол тэжээлийн **тандалтын систем**.
- Эрүүл бус хоол хүнсний татварыг өндөр байлгахын зэрэгцээ байгальд ээлтэй технологи, аргаар үйлдвэрлэсэн **эрүүл хүнсэнд татварын хөнгөлөлт**, татаас үзүүлдэг байх.
- Хэрэглэгчийг **эрүүл хүнс, хооллолтод** хандуулах.
- Эрүүл хүнс, хоол тэжээлийн талаарх **иргэдийн боловсрол, хандлага, зан үйл**: гарын авлага, заавар, сургалт, зөвлөгөө, сургалтын хөтөлбөрт тусгах.



# Бага насны хүүхдийн хөгжил

- Агаарын бохирдол, хар тугалга зэрэг бохирдлоос хүүхдийг хамгаалах, цэцэрлэг болон бага насны хүүхэд өсч, хөгжиж байгаа орчинд **эрүүл орчныг бүрдүүлэх** (Цэвэр эрчим хүч, агаар цэвэршүүлэгч, барилга байгууламжийг дулаалах, агаар сэлгэх систем)
- Эрүүл хөгжлийг дэмжиж **олон нийтийн ойлголт, мэдлэг**ийг дээшлүүлэх, иргэдийн санаачлагыг дэмжих
- Хүүхдийн тоглоомын газар, парк, цэцэрлэг бүх хүүхдэд, хүнд **хүртээмжтэй байх**. Энэ нь хүүхдийн бие мах бод, хөдөлгөөний хөгжил, тоглоомоо сурах, байгалийг хайрладаг болох, шинжлэх ухааныг сонирхох гээд ихээхэн ач холбогдолтой.
- **Ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх,**
- Хүүхдийг багаасаа байгаль, цаг уурын янз бүрийн нөхцөл, өөрчлөлтөд **тэсвэртэй, дасан зохицох чадвартай** болж өсч торнихыг дэмжих.





# Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон нийгмийн хамгаалал

- Байгалийн гамшигтай уялдуулан тооцсон эрсдэл, эмзэг байдлын индекс
- Индекс, тооцоололд үндэслэн иргэд, өрхөд тусламж үзүүлэх төсвийн хуваарилалт /жишээ нь гэнэтийн цочрол хүйтэн, зудын үед бэлэн мөнгөний тусламж үзүүлэх/.
- Хүүхдийн эрсдэл, эмзэг байдлын асуудлыг салбар дундын, бүсийн хөгжлийн бодлого, үндэсний бодлогод тусгах
- Өсвөр үеийнхэн, залуучуудын хэрэгцээ, эрх, эмзэг байдал, чадавхыг авч үзэж байх, тоо баримт, нотолгоог бий болгох, оролцоог хангах



**Making Climate and Environment Policies** *for & with Children and Young People*

# Unite for children's environmental rights

## Хүүхэд хамгаалал

- Хүүхэд хамгааллын тогтолцоо нь гамшгаас урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэх, гамшгийн үед үйлчилгээг хүүхдэд хүргэх чадавхтай, хөрөнгө санхүүжилттэй байх.
- Хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд гамшгийн үед зайлшгүй хариу арга хэмжээ авах үүрэг хүлээн ажиллах бэлтгэлтэй, чадавхтай.
- Гамшгийн үед шилжин суурьших, нүүлгэх шилжүүлэх, хил дамнан цагаачлахад хүрсэн хүүхдүүдийг аюулгүй нөхцөлд байлгах, хамгаалалтад авах.
- Жендэрт суурилсан хүчирхийлэл, хор хөнөөлтэй үйлдлүүд (янз бүрийн хэлбэрийн хүчирхийлэл, насанд хүрээгүй охидын гэрлэлт, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл гэх мэт)-ээс сэргийлэх, хамгаалах, бууруулах, хариу арга хэмжээ авахын тулд байгууллага, иргэдтэй хамтран ажиллах.



# Эрүүл, аюулгүй орчинд амьдрах хүүхдийн эрхийг, уур амьсгал, байгаль орчны шударга зарчмыг хангах

- **Мэдээлэл:** Урьдчилан сэргийлэх мэдээлэл, дохиоллын систем, УАӨ-ийн хэрхэн нөлөөлдөг талаар мэдлэгтэй байх, үүнээс хэрхэн сэргийлж, хамгаалж болох ямар шийдэл, боломж байдаг талаар мэдээлэл авах боломжтой, мэдээллийн технологи, Интернет ашиглах боломж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн мэдээлэл, мэдлэг авах боломжтой байх.
- УАӨ-ийн нөлөөтэй холбоотойгоор хүүхдийн **эрхийг хангах эрх зүйн орчныг** бүрдүүлэх
- Хүүхэд залуучуудын хэрэгцээ, эрх ашгийг сонсож, асуудлыг хэлэлцэх, шийдвэр гаргахад **оролцоог нь хангах платформыг** бий болгох.
- Залуучуудын ногоон технологийн **шийдэл, инновацийг дэмжих.**







БАЯРЛАЛАА